



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/316

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг зохион байгуулах тухай" А/88 дугаар тушаал, Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн "Аргачлал шинэчлэн батлах тухай" А/16, А/04 дүгээр хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Чинбат (аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд: С.Мөнхжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
Н.Энхтуяа (Татварын хэлтсийн дарга)
Г.Чүлтэмжамц (Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)
Л.Энхжаргал (Нийгмийн даатгалын хэлтсийн дарга)
Д.Тунгалаг (Статистикийн хэлтсийн дарга)
Б.Алтайбаатар (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)
Ц.Лувсанжамц (Онцгой байдлын газрын дарга)
Н.Мэндбаяр (Цагдаагийн газрын дарга)
Г.Лхагважаргал (Эрүүл мэндийн газрын дарга)
А.Алтанхуяг (Есөнбулаг сумын Засаг дарга)
Нарийн бичгийн дарга: Д.Баттайван (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

2.Аймгийн хэмжээнд мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, удирдлага арга зүйгээр хангаж, хугацаанд нь тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

